

ЭКОЛОГИ ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ТУХАЙ

Ш.Ганхуяг (Ph.D)

Г.Мэнд-Амар (Докторант)

МУИС, НШУС.

Философийн Тэнхим

Түлхүүр үг: Экологи, экологийн аюулгүй байдал, байгаль, байгаль хамгаалал, байгаль орчин, хүрээлэн буй орчин, тогтвортой хөгжил, орчин зүй.

Товч утга: Энэхүү өгүүлэлд эрдэмтэн судлаачдын болон орчин үед хэрэглэгдэж байгаа экологи, байгаль орчны талаарх ойлголт, тодорхойлолтуудыг харьцуулах; тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх; эл ойлголтын талаар шинэ тодорхойлолт өгөхийг зорилоо.

“Тодорхойлно гэдэг нь юмсын мөн чанарыг илэрхийлнэ гэсэн үг. Үүний тулд хамгийн ойрын төрөл, онцгой ялгааг олох хэрэгтэй”¹. Жишээ нь хүн гэдэг ойлголтыг тодорхойлохын тулд энэ бол зөвхөн амьд амьтан төдийгүй, хамгийн гол ялгаа нь рациональ сэтгэлтэй байдагт оршино. Шинжлэх ухаан бүхэн өөртөө тохирсон зарчмыг хэрэглэдэг. Юуны түрүүнд судлах зүйлээ тойрсон бүх ойлголтын хүрээг тогтооно. Ийнхүү тодорхойлолтоор дамжуулан судлах зүйлээ тогтооно. Экологийн тухай шинжлэх ухаан үүссэн үеэс эхлэн судлаачид олон янзын тодорхойлолтуудыг өгч ирсэн билээ. Үүнд: ургамал, амьтны аймагт голчлон анхаарч, хүнийг зөвхөн орчинд үзүүлэх нөлөө нь бусдаас онцгой зүйл гэж үзэж иржээ.

Орчин үед байгаль орчин тэдгээрийн талаархи ойлголт улам өргөжихийн хирээр, тэдгээр нь хоорондоо ямар холбоо харилцаатайг тодруулан, онцлогыг нь гаргах явдал чухал болж байна. Энэ өгүүлэлээр, судлаачдын экологи, байгаль орчин, хүрээлэн буй орчин, зэрэг ойлголт, тодорхойлолтуудад үнэлгээ дүгнэлт хийх шинээр тодорхойлт өгөхөд оршино.

XX зуунд экологийн тухай шинжлэх ухаан үүссэнээр байгаль орчин тэдгээрийн холбоо харилцааны талаар олон тодорхойлолтуудыг өгчээ. Экологи нь грек хэлний /oikos-гэр, оромж, logos-шинжлэх ухаан/ гэсэн үгнээс гаралтай нэр томъёо² юм.

Экологи гэдэг нэр томъёог анх америкийн зохиолч, философич Г.Д.Торо (1817-1862) хэрэглэжээ. Германы дарвинист биологч Э.Геккель (1834-1919) энэ нэр томъёог 1866 онд шинжлэх ухааны утгаар эргэлтэд оруулсан байна. Түүний үзлээр “экологи гэж байгалийн нөөц, амьдрал ахуйн хэв маяг, организмууд бие биетэйгээ харилцах гадаад харилцааны тухай шинжлэх ухаан”³ гэж тодорхойлсон байна. Энэ нь байгалийн тэнцвэрийн тухай, амьд бие ба түүнийг хүрээлэн буй орчны органик ба органик бус бүрэлдэхүүн хэсгийн хоорондын харилцан хамаарлын тухай, байгаль дахь хамгийн нийлмэл холбоо, хамаарлыг судалдаг шинжлэх ухаан юм. Байгалийн нөөц нь организмын ахуйн хэв маягийг тодорхойлдог. Энэ нь организмын хоорондын харилцааг илэрхийлдэг болно. Нөөц баялаг гэдэг бол организм орчинтойгоо харилцах гадаад харилцааг илэрхийлагч гол хүчин зүйл гэж онцолсон байна.

Мөн олон экологич эрдэмтэд экологийн талаар янз бүрийн тодорхойлолтууд өгсөн байдаг. Английн эрдэмтэн Ч.Элтон (1900-1991) “Амьтдын экологи” (1930) номондоо экологи нь

1. Ш.Ганхуяг, М.Гантуяа, Философийн түүхэн тойм, УБ., 2006. 109 дэх тал

2. Энциклопедический словарь по культурологии. /Под общей редакцией доктора философских наук. Профессора А.А.Радуга. Москва “Центр” 1997. с 451

3. Всемирная энциклопедия: Философия. Харвест., 2001. с. 1251

эд эсийн болон бие организмын патогенезийн асуудлаас авахуулаад хувьсал ба дасан зохицол хоорондын харьцаа болон социологийн асуудлуудыг оролцуулан (хүн амын суурьшлын онол) өргөн хүрээтэй асуудлуудыг судалдаг байгалийн түүхийн шинжлэх ухаан гэж тодорхойложээ. Бичил эд эс болон амьд организмын үүсэл, хувьсал дасан зохицлыг илэрхийлэх түүхэн зүй тогтлыг онцолж байна. Энэхүү түүхэн зүй тогтолд хүний нийгэм хэрхэн хөгжиж ирсэн талаар дурджээ.

Оросын академич С.С.Шварцын (1919-1976) үзлээр организм орчин хоёрын харилцааны тухай сургаал болж үүссэн экологи нь биднийг харсаар байтал байгалийн бүрэлдэхүүний тухай, дэлхийн амьд бүрхэвч бүхэлдээ яаж ажилладаг тухай шинжлэх ухаан болон хувирчээ. Экологи нь үйлдвэрийн нийгэмд хүний байгальд хандах зан байдлын онолын үндэс болж байна гэж тодорхойлжээ. Байгаль орчин ба организмын уялдаа холбоо, дэлхийн гадаргуу хэрхэн үйл ажиллагаагаа явуулдаг тухай амьд организм нь байгаль орчинтойгоо хэрхэн дасан зохицож, амьтдын амьдралын хэв маягыг онцолж үзсэн байна.

Оросын эрдэмтэн В.В.Петров экологи гэдэг бол амьд организм өөрийгөө хүрээлэн буй байгаль орчинтой харилцан үйлчлэх тухай сургаал мөн гэж үзсэн байна. Экологи гэдэг нь амьд организм болон байгаль орчны зохистой харьцааг илэрхийлдэг ойлголт юм. Хүний нийгмийн орчинд хүрээлэн буй орчин гэх ойлголт илүү тохиромжтой юм. Экологи, хүрээлэн буй орчны зохистой харьцааг тогтоох нь тодорхойлолтын агуулгыг гаргаж буй хэлбэр юм.

Америкийн эрдэмтэн Юджин Одум (1913-2002) экологи нь организм ба хэсэг организмаас хүрээлэн буй орчинд харьцах харьцаа, мөн амьд организмуудын хоорондын болон тэдгээрийн оршин тогтнох орчин хоорондын хамтын харилцааны тухай шинжлэх ухаан юм гэжээ. Түүний тодорхойлолтын онцлог нь амьд организмуудын хоорондын харилцааг онцолж байна. Тухайлбал нийгэм гэдэг нь хүмүүсийн хоорондын харилцаа хэр боловсронгуй байна, тэр хэмжээгээрээ хөгжиж байдаг онцлогтой. Тийм ч учраас Аристотель хүнийг улс төрийн /нийгмийн/ амьтан гэж тодорхойлжээ.

Р.Дажогийн үзлээр экологи гэдэг нь амьд организм нь хүрээлэн буй орчинтойгоо харилцан үйлдэлд орших нөхцөлийг судалдаг шинжлэх ухаан юм. Энэ тодорхойлолтод зөвхөн амьд организм хүрээлэн буй орчны хоорондын харилцан үйлдэлд орших нөхцөл болон нөлөөлөлд оршиж байдаг гэж үзжээ. Мөн байгалийн үзэгдэл хоорондын харьцаа маш чухал юм. Жишээлбэл: Далай, тэнгисээс алслагдмал, хур тунадас багатай нутаг дэвсгэр бол говь, цөлийн бүсэд хамаарагдах магадлал өндөр байдаг. Орчны бүрдэл нь байгалийн үзэгдэл хоорондын нөлөөллөөс үүсдэг онцлогтой.

Английн эрдэмтэн Ч.Дарвин (1809-1882) экологийг "Оршин тогтнохын төлөө тэмцэл болон байгаль дээрх харилцан холбооны бүх талуудыг судалдаг"⁴ гэж тодорхойлсон. Байгалийн харилцан холбооны бүх тал гэдэгт чулуун мандал, агаар мандал, газар зүй, цаг уур, ургамал, ан амьтан зэрэг нийгмийн харилцааны талуудыг ч хамарч ойлгоно. Амьд биений амьдрал, хөгжилд орчин, орчны нөхцөл, орчны хүчин зүйл гэсэн ойлголтыг онцгойлон авч үзэж байна. Орчин, орчны нөхцөл, орчны хүчин зүйл хэмээх биологийн ойлголт нь нийгмийн хөгжлийн олон асуудалтай холбогдож байна. Харин байгаль ба нийгэм дэх орчин, орчны хүчин зүйлийн үйлчлэх хугацаа, хүрээ хязгаар, түүнтэй зохилдох зүй тогтол, үр дүн нь эрс өөр билээ. Энэ тухай дээрх адилтгалуудад хүний ухамсарт үйлдэлтэй холбоотой зарчмын гол ялгаа байдаг. Тухайлбал, амьд биений эволюц нь хэдэн миллиард, хүний эволюц нь хэдэн сая жил үргэлжилсэн бөгөөд орчин үеийн хүний иргэншил үүсэн хөгжсөн дөнгөж долоогоос найман мянган жилд л байгаль-дэлхийн унаган төрх хэрхэн алдагдсаар байгааг хүний нийгэмтэй холбон авч үзэхээс аргагүй. Байгаль, нийгмийн хөгжлийн шүтэн барилдлагыг зөв ухаарч зохицуулан тэнцвэржүүлэх ёстойг байгаль өөрөө, хүн төрөлхтөнд сануулсаар байна.

Нэрт экологич Чарльз Ж.Кребс "Экологи нь амьд биесийн тархалт, элбэгшлийг

нөхцөлдүүлэгч харилцан шүтэлцээг судлах шинжлэх ухаан⁵ хэмээн тодорхойлжээ. Үүнийг тайлбарлан үзвэл аливаа амьд биесийн тархалтын төлөв байдал нь түүний их багын хэмжээний тухай төсөөллийг бидэнд өгч байдаг. Харин тэдгээрийн тархалт нь яагаад их юмуу бага байгаа, тоо толгой, тархац нь мөн л их юмуу бага байгаа тухай асуудалд экологийн ухааны үүднээс хариу өгөх учиртай юм. Өөрөөр хэлбэл амьд бие махбодын тархалт, элбэгшлийг нөхцөлдүүлж буй эдгээр олон хүчин зүйлийн харилцан хамаарлын шалтгаан нөлөөлөл, үр дагаварыг судлах нь экологийн ухааны зорилт хэмээн тэрээр үзжээ. Түүнчлэн тархалт, элбэгшлийн зэрэгцээ ан амьтдын хорогдол, устаж буй нөхцөл байдлыг ч судлах ёстой. Амьд амьтдын биесийн тоо толгойн өөрчлөлт бол экологийн судалгааны нэг чухал нөхцөл болох нь зайлшгүй юм.

Манай орны зарим эрдэмтэд ч экологийн талаархи тодорхойлолтуудыг өгч ирсэн байна. Тухайлбал хууль зүйн ухааны доктор Т.Сэнгэдорж “Экологи хэмээх ойлголт байгаль орчин гэсэн ухагдахуунтай утга ойролцоо юм”⁶ гэж тодорхойлжээ. Үүнийг тайлбарлан үзвэл экологи нь байгалийн орчин гэхдээ хүн тэнд болж буй амьдралын нөхцөл боломжийг судлан үзсэний үндсэн дээр илэрхийлсэн ойлголт болох юм. Жишээлбэл: Говь, цөлийн ургамлын, ойт хээрийн бүсийн ургамлын экологи өөр өөр нөхцөлд амьдардаг онцлогтойг судлан үзсэн байна.

Доктор О.Амархүү “Экологи гэдэг бол байгаль орчны асуудлыг хамаарсан шинжлэх ухааны шинэ чиглэлийг интеграцчилсан хэлбэрээр томъёолсны илэрхийлэл гэж хэлж болно”⁷ гэж тодорхойлжээ. Үүний онцлог нь шинжлэх ухааны аливаа бүх чиглэл нь экологитой ямар нэг холбоо хамааралтай байдаг. Хүн эдгээр шинжлэх ухааны чиглэлүүдийг судлан хөгжүүлдэг. Мөн оршин ахуйн хамгийн анхдагч хэлбэр болох байгаль дэлхий нь тухайн шинжлэх ухаануудын судалгааны объект болдог.

Дээрх бүх тодорхойлолтуудаас үзвэл экологи гэдэг бол байгаль орчин, байгалийн тэнцвэрийн тухай, нөөц баялаг, амьд биес нь хүрээлэн буй орчинтойгоо харьцах, харилцан үйлдэлд орших, оршин тогтнохын төлөө тэмцэл, орчиндоо дасан зохицох, тархалт элбэгшлийг нөхцөлдүүлэгч, дэлхийн амьд гадаргуугийн үйл ажиллагааны тухай шинжлэх ухаан, байгалийн түүхийн шинжлэх ухаан, байгаль орчны шинжлэх ухааны интеграцчилагдсан хэлбэр зэрэг олон талаас нь гадаад дотоодын эрдэмтэд тодорхойлсон байна. Үүнийг товчлон үзвэл экологийн онцлог нь хүнтэй холбоотой ойлголт юм. Өөрөөр хэлбэл энэхүү ойлголтыг бий болгож түүний хүрээнд шинжлэх ухааны судалгаа шинжилгээ практик ач холбогдол бүхий зүйлд хэрэглэж болох юм. Амьтад зөвхөн зөнгөөрөө л байгальд амьдарч байдаг. Хүн нийгмийн хөгжлийн явцад хүрээлэн буй орчинд нөлөөлж, улмаар бий болсон эерэг болон сөрөг аливаа үйлдлийг шийдвэрлэхийн тулд амьтдын экологи гэх мэт ойлголтуудыг бий болгож тэдний амьдарч буй байгалийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авдаг.

Иймд экологи гэдэг нь байгаль орчинд болж буй амьдрал, үйл ажиллагааны талаархи эерэг болон сөрөг аливаа үйл явцад үнэлгээ өгч, түүний үр дүнд байгаль, нийгмийн шинжлэх ухааны үүднээс судлан шинжилж буй хүний цогц үйл ажиллагааны илэрхийлэл болох юм гэсэн тодорхойлолтыг судлаачийн хувьд өгч байна.

“Экологийн аюулгүй байдал гэж байгаль цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ”⁸ гэж заажээ.

Орчин үед экологийг организм хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн харилцах тухай асуудлыг судалдаг шинжлэх ухаан гэж ойлгох явдал нэлээд түгээмэл дэлгэрсэн байна. Үүнээс өөр тодорхойлолтууд ч бий. Тухайлбал, организмын амьдралын үйл ажиллагааны зүй тогтлыг төрөлх орчинтой нь, түүнд хүний нөлөөллөөр орсон өөрчлөлттэй холбоотойгоор судалдаг шинжлэх ухаан гэж үздэг. Үүнээс үүдэн байгаль, байгаль орчин, хүрээлэн буй орчин гэсэн

5. Х.Тэрбиш, Я.Адъяа “Экологи” УБ., 2009. 5 дахь тал

6. Т.Сэнгэдорж. “Экологийн эрх зүй”. УБ., 1997. 6 дахь тал

7. О.Амархүү. Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз. УБ., 2000. 97 дахь тал

8. Х.Мөнхбаяр, Мөнхбаатар. “Хялбаршуулсан экологи” УБ., 2006. 6 дахь тал

ойлголтууд урган гарч ирж байгаа бөгөөд эдгээр ойлголтуудыг тодруулан авч үзэх шаардлагатай гэж үзэж байна юм. Эдгээр томъёолол хэдийгээр өөр хоорондоо эрс тэс ялгаатай биш боловч багтаамжийн хувьд чухам аль нь илүү өргөн хүрээг хамарч чадах вэ гэдэг асуудлыг авч үзэх нь судалгааны ажлыг гүнзгийрүүлж, шинжлэх ухааны үндэслэл бүхий зөв зүйтэй дүгнэлт хийхэд ач холбогдол өгнө.

“Байгаль”, “байгаль орчин”, “хүрээлэн буй орчин” гэсэн гурван янзын нэр томъёоны тус тусын утга агуулга, нийтлэг болон ялгаатай талуудын талаар авч үзье.

Байгаль гэдэг ухагдахуун бол байгалийн өөрийнх зүй тогтлоор бий болж, байгаль, нийгэм, хүн бусад амьд организмын оршин тогтнож, үржин төлжиж, нөхөн сэргээгдэж, хөгжин дэвшиж байх хамгийн гол нөхцөл, суурь үндэс нь болсон төрөл зүйл газар, ус, ой, ургамал, ан амьтан, байгалийн бусад баялгийг хамаарч байдаг ойлголт юм. Философийн үзлээр байгаль нь хязгааргүй олон янзаар илрэх биднийг хүрээлэн буй ертөнц юм. Эхлэл төгсгөлгүй орон, цагт хязгааргүй мөнхийн хөдөлгөөн, өөрчлөлттэй байдаг ертөнцийн нэг хэсэг болох манай гаригийн биосферийг байгаль гэж нэрлэдэг байна. Байгаль бол ухамсраас ангид хараат бус оршигч объектив бодит чанар юм. Байгалийн түрүүч хөгжлийн явцад бий болсон биосфер л чухамдаа хүн үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ. Өрнөдийн агуу их сэтгэгч Аристорель “бүх хүн байгалиас мэдлэг рүү тэмүүлж байдаг” гэж үзсэн нь байгаль нь хүний нийгмийг хөгжүүлэх эх үндсийг илэрхийлжээ гэж ойлгож болох юм. Тэрээр байгалийн оршин ахуйг хоёр талтай гэж үзжээ. Нэг талаас тэр нь матери, нөгөө талаас хэлбэр юм.

Байгаль гэдэг ойлголтын орчин үед хамгийн түгээмэл хэрэглэгдэж байгаа нэг хэлбэр нь байгаль хамгаалал гэдэг нэр томъёо юм. Байгаль хамгаалал гэдэг нь “байгалийн унаган төрх байдлаа хадгалсан газар нутгийн экосистемийн нэгдэл үйл ажиллагаа, түүний өөрийгөө нөхөн сэргээх чадварыг хангах, аливаа амьд биет ховордож, устахад хүрч байгаа шалтгааныг судлан тогтоох, улмаар ховордсон ургамал, амьтны зүйлийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх”¹⁰ үйл ажиллагааны цогцыг хэлнэ. Аливаа ургамал, амьтны зүйлийг түүний төрөлх өлгий болсон байгалийн амьдрах орчинд нь хамгаалах зорилго тавьдгаараа байгаль хамгаалах ажил хүн төрөлхтний ёс суртахууны эрхэм, нандин чанарыг өөртөө агуулдаг. Биологийн олон янзын байдал тогтвортой хадгалах нөхцөл бүрдвэл хүн төрөлхтөн эрүүл орчинд амьдрах асуудал шийдэгдэнэ.

Нийгмийн хөгжлийн явцад хүний гараар бий болсон байгалийн бүтээгдэхүүнүүд үүсэх эх үндэс болно. Энэ нь “Байгаль орчин”, “Хүрээлэн буй орчин” зэрэг ойлголтуудыг бий болгоно.

Байгаль орчин гэдэг ухагдахуун бол “байгаль” гэдгийг илүү өргөн хүрээнд авч үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл дээр дурдсан байгалийн зүй тогтлоор бий болсон төрөл зүйлс дээр хүний үйл ажиллагаагаар бий болсон бөгөөд байгальд өөрт нь ч, хүн, бусад амьд организмд ч аль алинд нь аятай тохитой нөлөө үзүүлдэг бүтээгдмэл төрөл зүйлс-тарьж ургуулсан мод, бут, сөөг, зүлэг, цэцэрлэг, хиймэл нуур, цөөрөм зэрэг ой, ус, өсгөж үржүүлсэн ан амьтан зэргийг нэмж, тэдгээрийг байгальтай нь хамтад нь хамаарч байдаг ойлголт юм.

“Хүрээлэн буй орчин” гэдэг ухагдахуун нь “байгаль орчин” гэдэг дээр түүнийг бохирдлоос хамгаалах асуудлыг нэмж авч үздэгээс гадна хүн, байгалийн хоорондын өргөн харилцааг илэрхийлдэг гол хүчин зүйл болсон ухамсар, хүмүүжил, мэдлэг, соёл гэх мэт нийгмийн хэрэгцээний асуудлыг ч өөртөө багтаадаг маш өргөн хүрээтэй, нийгмийн олон талт харилцааг цогцолбороор хамаарч байдаг гэж үзэж болох юм.

“Хүрээлэн буй орчны судалгаа нь хүний байгаль дэлхийд үзүүлж буй нөлөөг задлан шинжилж, физик, хими, биологийн ухааны үүднээс тайлбарладаг. Экологи, газарзүй, цаг уур судлал зэрэг байгалийн шинжлэх ухааны салбараас гадна, нийгэм судлал, эдийн засаг, хүн судлал, улс төр, гүн ухаан зэрэг нийгмийн шинжлэх ухааны зүйлийг хамарсан цогц асуудлыг

9. А.Чанышев. Аристорель. М. 1987. с. 93

10. Б.Чадраа. О.Сүхбаатар. Монголын байгаль орчны нэвтэрхий тал. ШУА. УБ., 2010. 46 дахь тал

хөнддөг”¹¹ байна. Үүнийг харьцуулан үзвэл энэ нэр томъёог сүүлийн үед “байгаль орчин” гэх нэр томъёогоор илэрхийлэх болсон нь “байгаль” гэдэг нь дэлхийн унаган экосистемийг, “орчин” гэдэг нь хүний нийгмийн орчныг илэрхийлж буй онцлогтой байна. Иймд “байгаль орчин” гэдэг нь “хүрээлэн буй орчин” гэсэн санааг илэрхийлж, аль аль нь агуулгын хувьд адил тэнцүү харьцааг илэрхийлнэ. Хүрээлэн буй орчин гэх энэхүү ойлголттой утга дүйх нэг ойлголтыг орчин үед хэрэглэж эхэлсэн нь “тогтвортой хөгжил” хэмээх шинэ нэр томъёо юм.

Массачусетсын Технологийн их сургуулийн эрдэмтэд судалгааныхаа үр дүнгээр /Ромын клубт/ илтгэл тавьсан ба үүгээрээ олон улсын шилжилтийн үеийн стратегийн эхийг тавьсан. Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай 1992 оны 7 сарын НҮБ-ын бага хурал дээр “sustainable development” хэмээх зарчмыг тунхагласан. Энэ илэрхийлэл нь биологиос гадна сүүлдээ эдийн засгийн тайлбартай болсон бөгөөд “тогтвортой хөгжил” гэж орчуулагдаж бүх нийтээр хэрэглэж иржээ. Орчин үед тогтвортой хөгжлийг “улс орнууд ирээдүйнхээ өсөн нэмэгдэж байгаа хэрэглээний тогтвортой хэв маягийг хадгалан эдийн засгаа хөгжүүлэхдээ эрчим хүч, материал, түүхийн эдийн хаягдлыг багасган дэлхийн байгалийн нөөц баялгийн чадавхид зохицсон, хүрээлэн байгаа орчны тэнцвэрт байдлыг хангасан хэрэглээний тэнцвэртэй бүтцийг бий болгон хөгжих даян дэлхийн улс төр эдийн засгийн нэгдсэн бодлого /XXI зууны дэлхийн нийтийн хөгжлийн хандлага/¹² хэмээн тодорхойлсныг доктор Г.Баярсайхан судалгааныхаа ажилдаа онцолжээ. Ийм тогтвортой хөгжил нь хүний амьдрал ахуйн нөхцөлийг анхаарч материаллаг хэрэгцээ байгалийн нөөц баялаг, байгаль орчны эдийн засгийн үр ашиг, өсөлтийг нэмэгдүүлэх, нийгмийн хөгжлийг хангахыг юун түрүүн гол зорилтоо болгож байна.

Эдийн засгийг хөгжүүлж, хүний сайн сайхан аж төрөх бололцоог бүх талаар бүрдүүлэх гэсэн агуулга өнөө үед экологийн тэнцлийг хангаж бүх талын сайн сайхан байдлыг илэрхийлж чадахгүй юм. Учир нь хүн бол зөвхөн материаллаг хэрэгцээ төдийгүй, сэтгэл зүй, оюун санаа, нийгмийн харилцааны хувьд эрүүл, аюулгүй орчин нөхцөлд амьдарч, түүнд тулгуурласан нийгмийн хөгжлийг хангах явдал амьдралаас урган гарч байна. Өнөө үед амьдрал ахуйн хувьд бүрэн хангагдсан хөгжингүй гэгдэх дэлхийн тэргүүлэх улс орнуудад бусад төрлийн сөрөг нөлөөллүүд гарсаар байгаа явдал юм. Энэ нь хүний хүчин зүйлийн улмаас үүссэн сөрөг нөлөөлөл юм. Үүнийг өрнөдийн нэрт эрдэмтэн Самуэль П.Хантингтон авч үзэхдээ “1990-ээд оны үед олон улсын харилцаанд “жинхэнэ хаосын” зарчим үйлчилж байсныг илтгэх жишээ олон бий. Тухайлбал: дэлхий даяараа хууль ёс, дэг журмыг үл хайхран, улс орнууд дампуурч бутран, дэлхийн олон хэсэгт анархи байдал газар авч, дэлхий даяар гэмт хэрэг, үндэстэн дамнасан мафи, хар тамхины картел цэцэглэж, олон оронд хар тамхинд донтох явдал ихсэж, гэр бүл суларч, итгэлцэл болон нийгмийн эв нэгдэл унаж, олон улс орон угсаатан, шашин, иргэншлийн хүчирхийлэлд нэрвэгдэн, зэвсэгт хүчнээр маргааныг шийдвэрлэх явдал дэлхийд хязгаагүй тархсан билээ”¹³ хэмээн үзжээ. Иймд хүний хүчин зүйлийн улмаас үүссэн сөрөг нөлөөлөл нь нийгэм, хүн төрөлхтний амьдралд шийдвэрлэх ёстой асуудал болсоор удаж байна.

Иймд нийгмийн хөгжлийн бүхий л талыг хамарсан байгаль орчин, хүрээлэн буй орчин, экологи, нийгмийн орчны асуудлыг судлан үзэх тодорхой ойлголт бий болгож хөгжүүлэх шаардлага амьдралаас урган гарч байна. Ийм ойлголт бол өнөө үед “орчин зүй” гэх ойлголтоор илэрхийлэх явдлыг дэвшүүлж байна.

Иймд орчин зүй гэдэг нь байгаль, байгалийн орчин хүн түүний бүтээсэн бүтээгдмэл төрөл зүйлс, хүний амьдрал ахуйн нөхцөлийг анхаарч материаллаг хэрэгцээг байгалийн нөөц баялагт зохицуулж, ухамсар, хүмүүжил, мэдлэг, соёл гэх мэт нийгмийн харилцааны үнэт зүйлсийг хамаарч, хууль ёс, дэг журмыг сахиулан, хүнийн дотоод сэтгэц, сэтгэлийн эрүүл

11. Ж.Кребс. Экологи. Тархалт ба элбэгшлийн сорилын судалгаа. УБ., 2001. 7 дахь тал

12. Г.Баярсайхан. Эрс тэс уур амьсгалын нөхцөл дэх тамоохон хотын экологи, түүний хүн амд үзүүлэх нөлөөллийн судалгаа /Улаанбаатар хотын жишээн дээр/. УБ., 2004. 7 дахь тал

13. Самуэль П.Хантингтон. иргэншил хоорондын мөргөлдөөн. Шинэчлэгдэж буй дэлхийн дэг журам. УБ., 2005. 376 дахь тал

аюулгүй орчинд амьдрах бүх талын нөхцөлийг бүрдүүлсэн байдлыг товч утгаар тодорхойлж болох юм.

Эцэст нь дүгнэн үзвэл экологи, байгаль, байгаль орчин хүн, хүрээлэн буй орчин, тогтвортой хөгжил зэрэг эдгээр ойлголтуудыг хамарч, нийгмийн харилцааны тэр дундаа хүмүүсийн хоорондын харилцааны орчин үед алдагдаад байгаа хэлбэрүүд болох дээр дурдагдсан хууль ёс, дэг журмыг үл хайхрах, хүмүүсийн хоорондын үл итгэлцэл, ойлголцол зэрэг дутагдалтай талыг зохицуулахыг гол зорилт болгосноороо орчин зүйн талаархи нэг нэгдмэл ойлголтод хүрэх чухал ач холбогдолтой билээ. ХХI зууны дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлага нь аливаа орчин дахь харилцаа нь байгалийн нөөц, амьдрал ахуйн хэв маяг, организмууд бие биетэйгээ харилцах гадаад харилцааны бүх талыг цогц байдлаа тэр дундаа хүмүүсийн хоорондын харилцааг орчин үед шинэ шатанд гаргах явдал амьдралаас урган гарч байгааг илэрхийлж байна.

НОМ ЗҮЙ

1. Адьяасүрэн Ц. Байгаль орчин, тогтвортой хөгжил, хүний хөгжил. УБ., 2010
2. Амархүү О. Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз. УБ., 2000
3. Баярсайхан Г. Эрс тэс уур амьсгалын нөхцөл дэх томоохон хотын экологи, түүний хүн амд үзүүлэх нөлөөллийн судалгаа (Улаанбаатар хотын жишээн дээр). УБ., 2004
4. Ганхуяг Ш, Гантуяа М. Философийн түүхэн тойм. УБ., 2006
5. Ганхуяг Ш. Соёл иргэншил дэх байгалийн ба соёлын хүчин зүйлийн харилцан хамаарал. УБ., 2004
6. Гүрбадам А. Хүний экологи. УБ., 2008
7. Кребс Ж. Экологи. Тархалт ба элбэгшлийн сорилын судалгаа. УБ., 2001
8. Мөнхбаяр Х, Мөнхбаатар. Хялбаршуулсан экологи. УБ., 2006
9. Хантингтон. Самуэль П. Иргэншил хоорондын мөргөлдөөн. Шинэчлэгдэж буй дэлхийн дэг журам. УБ., 2005
10. Сэнгэдорж Т. Экологийн эрх зүй. УБ., 1997
11. Тэрбиш Х, Адьяа Я. Экологи. УБ., 2009
12. Философи I хэсэг. Философийн түүх. УБ., 1999
13. Чадраа Б, Сүхбаатар О. Монголын байгаль орчны нэвтэрхий толь. ШУА. УБ., 2010
14. Всемирная энциклопедия: Философия. Харвест., 2001
15. Маркович Данило Ж. Социальная экология. М., 1997
16. Чанышев А. Аристотель. М., 1987

SUMMARY

Researchers have defined ecology in number of ways since it was first originated. In modern times, the more concepts about nature expand, the more important it is getting to emphasize and highlight interconnection between them. Concepts such as ecology, nature, environment and sustainable development have been considered comparatively.